



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 53


Есөнбулаг сум

"Алтайн малчин" төсөл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.14 дэх заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. "Алтайн малчин" төслийг хавсралтаар баталсугай.
2. Төслийн хэрэгжилтийг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөв, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган батлуулж, биелэлтийн явцыг жил бүрийн IV улиралд багтаан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.


ДАРГА



Т.ГАНЗОРИГ

142

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 05 дугаар сарын 31-ний
өдрийн 53-р тогтоолын хавсралт



“АЛТАЙН МАЛЧИН” ТӨСӨЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

Хөдөө аж ахуй нь манай улсын уламжлалт салбар бөгөөд дотоодын нийт бүтээгдэхүүний багагүй хувийг үйлдвэрлэж хүн амын хүнсний хангамж, үндэсний үйлдвэрийн түүхий эдийн гол тулгуур болж байгаагийн хувьд улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн төвшинг тодорхойлох нэг үндэс байсаар ирсэн, одоо ч энэ ач холбогдлоо алдаагүй байна. Энэ үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, улс орны боловсруулах үйлдвэрийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад зориулагдаж байдаг.

Манай аймгийн эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар, үүн дотроо мал аж ахуйн салбар гол байр суурь эзэлдэг бөгөөд 2015 оны гүйцэтгэлээр манай аймгийн

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 50.3 хувийг хөдөө аж ахуйн салбар бүрдүүлж байгаа ба ажиллах хүчний 49.2 хувь, ажиллагсадын 54 хувь нь энэ салбарт ажиллаж байна.

Салбарын бүтцээр анхдагч хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбар нь аймгийн ДНБ-ий 60.0-80.0 шахам хувийг эзэлсээр байсан ба 2002 оноос хойшхи хөдөө аж ахуйн салбарт авчирсан байгалийн гамшгаас үүдэн мөн үйлчилгээний салбарын өсөлтөөс шалтгаалж хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хувийн жин буурч, улмаар үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын эзлэх хувийн жин өссөөр байна.

Аймгийн хэмжээгээр 2016 оны мал тооллогын дүнгээр мал бүхий 9.6 мянган өрх тоологдсон байна. Үүний 68.3 хувь буюу 6.4 мянган өрх жилийн 4 улирлын турш малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа малчин өрх, 31.6 хувь нь буюу 3.0 мянга нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй өрх байна. Аймгийн нийт өрхийн 40.8 хувийг малчин өрх эзэлж байна.

Малчдын насны бүлгээр авч үзвэл 35.4 хувь 15-34 насны , 55.5 хувь нь 35 наснаас тэтгэвэрт гарах насныхан, 9.1 хувь нь тэтгэвэрийн насны хүмүүс байна. 2015 оны байдлаар нийт малчин өрх малчдын тоо буурах хандлагатай байна.

Малчдын тоо

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015
Малтай өрх	9505	9246	9264	9395	9428	9602
Малчин өрх	7185	6994	6644	6537	6436	6658
Малчдын тоо	14776	13889	13311	13118	12949	13294
Үүнд: 15-34 насны	6372	5684	5191	4896	4586	4726
Эзлэх хувь	43.1	40.9	39.0	37.3	35.4	35.5
35-59 насны	6659	6587	6792	6917	7189	7333
Эзлэх хувь	45.1	47.4	51.0	52.7	55.5	55.2
Тэтгэвэрийн насны	1745	1618	1328	1305	1174	1235
Эзлэх хувь	11.8	11.6	10.0	9.9	9.1	9.3
4.Нийт малчдаас эмэгтэй	6725	6391	6459	6301	6216	6268
Малчин нэг өрхөд ноогдох						
малын тоо	157	196	288	340	401	439

Малын тоо 2016 оны жилийн эцсийн тооллогын дүнгээр бүх төрлөөр өсч, бүгд гурван сая 497.5 мянган толгой мал тоолууллаа. Үүнд тэмээ 38.5 мянга, адуу 106.8 мянга, үхэр 71.1 мянга, хонь 1107.1 мянга, ямаа хоёр сая 173.9 мянган толгой байна. Тухайлбал нийт мал 344.4 мянгаар үүнээс тэмээ 2.0 мянгаар, адуу 11.6 мянгаар, үхэр 9.4 мянгаар, хонь 111.1, ямаа 210.3 мянгаар тус тус өслөө.

Малын тоо

Сум	2015	2016					
	Бүгд	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Алтай	85835	106433	2418	2397	1846	18966	80806
Баян-Уул	202739	245497	1850	8189	4811	91557	139090
Бигэр	149155	173436	1948	5225	6247	43574	116442

Бугат	121349	150948	1304	3604	1703	48105	96232
Дарив	164559	194413	1655	7716	4054	75457	105531
Дэлгэр	236000	261217	2238	6921	4656	91450	155952
Жаргалан	139620	165991	890	4257	4289	58427	98128
Тайшир	98480	118192	539	3754	2991	43986	66922
Тонхил	201809	240137	440	9639	3815	113578	112665
Төгрөг	134794	156849	5335	5976	2375	55784	87379
Халиун	204958	240824	3493	7372	5822	74715	149422
Хөхморьт	122465	153372	3024	9731	4482	51294	84841
Цогт	222601	277604	2737	4531	5735	71364	193237
Цээл	165880	192292	1528	5794	3993	46095	134882
Чандмань	164567	199180	1187	5205	2710	68346	121732
Шарга	138038	161683	4933	5313	4795	34575	112067
Эрдэнэ	205003	249814	2179	3639	1282	48007	194707
Есөнбулаг	164719	209610	842	7580	5452	71834	123902
Дүн	292251	3497492	38540	10683	71058	1107114	2173937

Үүнээс харахад мал аж ахуйн салбарын хөгжлийг эрчимжүүлэх, мал сүргийн өсөлтөд нөлөөлж буй сөрөг нөлөөг багасгахын тулд малчдын хөдөлмөрийг нэгтгэх, ашиг шим өндөртэй цөөн тооны мал өсгөх, сүргийн бүтцийн зохистой харьцааг хангах, сүү мах, малын гаралтай түүхий эд боловсруулах, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Мөн залуу малчдын тоо жилээс жилд буурч байгаа үед мал маллагааны уламжлалт арга ухааныг залуу хойч үед сургах, суурьшуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Хоёр. Төслийн зорилго

Залуу малчдад мал маллах уламжлалт арга ухааныг өвлүүлэх, тэдний ажлын байрыг тогтвортой хадгалах, өргөжүүлэх зорилгоор малжуулах арга хэмжээг зохион байгуулахад төслийн зорилго оршино.

Гурав. Төслийн зорилтууд

1. Мэргэжлийн байгууллага, алдар цолтой ахмад малчдын ажлын дадлага, туршлагыг залуу малчдад өвлүүлэх, туршлага судлуулах, амьдрах арга ухаанд сургана.
2. 100 хүртэлх толгой малтай 40-өөс доош насны малчин өрхийг нэгжээс авах ашиг шим өндөртэй малаар малжуулна.
3. Залуу малчдад мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн боловсруулах ур чадварыг олгоно.

Дөрөв. Төслийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

- 4.1. Мэргэжлийн байгууллага, алдар цолтой ахмад малчдын ажлын дадлага туршлагыг залуу малчдад өвлүүлэх, туршлага судлуулах арга хэмжээг зохион байгуулна.**
 - 4.1.1. Монгол улсын гавъяат, хөдөлмөрийн баатар, улсын болон аймгийн сайн малчдын судалгааг сумдаар гаргаж мэдээллийн сан бүрдүүлнэ.
 - 4.1.2. Аймгийн хэмжээнд **“САЙН МАЛЧДЫН ХОЛБОО”**-Г байгуулж үйл ажиллагааг нь идэвхижүүлнэ.
 - 4.1.3. Алдар цолтой ахмад малчидтай хамтран мал маллах арга ухааныг залуу хойч үед өвлүүлэх ажлын хүрээнд Монголын үндэсний олон нийтийн радио, аймгийн радиотой хамтран **“Хөрөг”** нэвтрүүлэг зохион байгуулна.
 - 4.1.4. Нэвтрүүлэгт оролцсон мэргэжлийн болон ахмад зөвлөхүүдийн ажлын дадлага туршлага, зөвлөмжөөр гарын авлага ном товхимол хэвлүүлэн залуу малчдад хүргэнэ.
 - 4.1.5. Аймгийн малчдын зөвлөгөөнийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
 - 4.1.6. Хөтөлбөрт хамрагдсан малчин өрхийг туршлага судлуулах арга хэмжээнд хамруулна.
- 4.2. 40-өөс доош насны богд шилжүүлснээр 100 хүртэл толгой малтай малчин өрхийг малжуулна.**
 - 4.2.1. 40-өөс доош насны залуу малчдын судалгааг сумдаар нарийвчлан гаргах
 - 4.2.2. Залуу малчдыг хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.
 - 4.2.3. Цөөн малтай залуу малчдыг сумдын амьжиргааг дэмжих зөвлөлийн саналыг үндэслэн малжуулах арга хэмжээнд хамруулж ажлын байрны тогтвортой байдлыг хадгална.

146.

4.3. Мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн боловсруулах сургалт зохион байгуулах зорилтын хүрээнд:

4.3.1. Малчдаас ур чадвар олгох сургалтын хэрэгцээний судалгаа гаргана.

4.2.2. Эрэлтэд нь үндэслэн эрх бүхий сургалтын байгууллагатай хамтран сургалт зохион байгуулна.

Тав. Төслийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

3.1. Аймгийн Засаг дарга төслийн хүрээнд зохион байгуулагдах ажилд зарцуулах хөрөнгийг Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

3.2. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

3.3. Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь төсөлд хамрагдсан иргэдийг ажлын байраар хангах гэрээ байгуулж, үр дүнгийн талаарх мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, төслийн хэрэгжилтийн явц, үр дүнд байнга хяналт тавьж төслийг хэрэгжүүлнэ.

Зургаа. Төслийн хугацаа

6.1. Төсөл нь 2017-2020 онд хэрэгжинэ.

Долоо. Төслийн санхүүжилт

7.1. Төслийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

7.1.1. Төслийн нийт санхүүжилт 199,6 сая төг

А. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан /141,1 сая төг/

Б. Орон нутгийн төсөв 55,0 сая төгрөг

В. Олон улсын байгууллага 3,5 сая төгрөг

Найм. Төслийн хэрэгжилтийг тайлагнах,

хяналт шинжилгээ, үнэлгээ хийх

8.1. Төслийн хэрэгжилтийн явц, үр дүнд Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн салбар зөвлөл, Нийгмийн бодлогын хэлтэс байнгын хяналт тавина.

8.2. Аймгийн ХХААГазар мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.

8.3. Төслийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн үнэлгээг хагас, бүтэн жилээр аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хийж, тайлагнана.

8.4. Төслийн хэрэгжилтийг аймгийн Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Газар зохион байгуулна.

Ес. Төслийн үр дүн, шалгуур үзүүлэлт

8.1. Төсөлд хамрагдсан малчдын мэдээлэл хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн байх.

8.2. Төсөлд хамрагдсан малчдын өрхийн орлого нэмэгдсэн байх.

8.3. Залуу малчид мал маллах арга ухаанд суралцсан байх.

8.4. Үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг дараах хэмжүүрээр үнэлнэ. Үүнд:

Шалгуур үзүүлэлт	2017	2018	2019	2020	Хэрэгжүүлэх байгууллага
Малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрхийн тоо	45	45	45	45	ХХҮГазар
Зөвлөх үйлчилгээнд хамрагдсан алдар цолтой ахмад малчин/ мэргэжлийн байгууллагын тоо	40	40	40	40	ХХҮГазар
Ур чадвар олгох сургалтанд хамрагдсан малчин өрхийн тоо	30	30	30	30	ХХҮГазар
Малчдын зөвлөгөөн, туршлага судлах арга хэмжээнд оролцсон малчин өрхийн тоо	350	350	350	350	ХХҮГазар

**"АЛТАЙН МАЛЧИН" ТӨСЛИЙН 2017 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Зорилт		Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа 2017												Хэрэгжүүлэх байгууллага	
			1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар		
																ХХҮГазар
Нэг. Алтайн малчин төслийг боловсруулан батлуулах	1	"Алтайн-Малчин" төслийн төслийг боловсруулж, аймгийн ИТХурлаар батлуулах														ХХҮГазар
	2	Төслийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан ХХҮГ-ын даргаар батлуулж хэрэгжилтийг зохион байгуулах														ХХҮГазар
Хоёр. Ахмад алдар цолтой малчдын ажлын дадлага, туршлагыг залуу малчдад өвлүүлэх, туршлага судлуулах арга хэмжээг зохион байгуулна.	1	Монгол улсын гавъяат, хөдөлмөрийн баатар, улсын болон аймгийн сайн малчдын судалгааг сумдаар гаргаж мэдээллийн сан бүрдүүлнэ.														ХХҮГазар,
	2	Аймгийн хэмжээнд "САЙН МАЛЧДЫН ХОЛБОО"-Г байгуулж үйл ажиллагааг нь идэвхижүүлнэ.														ХХҮГазар,
	3	Алдар цолтой ахмад малчидтай хамтран мал маллах арга ухааныг залуу хойч үед өвлүүлэх ажлын хүрээнд Монголын үндэсний радио, аймгийн радиотой хамтран "Хөрөг" нэвтрүүлэг зохион байгуулна.														ХХҮГазар

	4	Нэвтрүүлэгт оролцсон ахмад зөвлөхүүдийн ажлын дадлага туршлага, зөвлөмжөөр гарын авлага ном товхимол хэвлүүлэн залуу малчдад хүргэнэ.																		XXҮГазар
	5	Аймгийн малчдын зөвлөгөөнийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.																		XXҮГазар
	6	Хөтөлбөрт хамрагдсан малчин өрхийг туршлага судлуулах арга хэмжээнд хамруулна.																		XXҮГазар
Гурав.39 хүртэлх насны богд шилжүүлснээр 100 хүртэл толгой малтэй малчин өрхийг малжуулна.	1	40-өөс доош насны залуу малчдын судалгааг сумдаар нарийвчлан гаргах																		XXҮГазар
	2	Залуу малчдыг хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.																		XXҮГазар,
	3	Цөөн малтай залуу малчдыг сумдын амьжиргааг дэмжих зөвлөлийн саналыг үндэслэн малжуулах арга хэмжээнд хамруулж ажлын байрны тогтвортой байдлыг хадгална.																		XXҮГазар,
Дөрөв. Малаас гарах түүхий эд бүтээгдэхүүн боловсруулах сургалт зохион байгуулна.	1	Малчдаас ур чадвар олгох сургалтын хэрэгцээний судалгаа авах																		XXҮГазар
	2	Эрэлтэд нь үндэслэн эрх бүхий сургалтын байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах																		XXҮГазар

"АЛТАЙН МАЛЧИН" ТӨСЛИЙГ 2017 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилт		Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа				Хэрэгжүүлэх байгууллага	Шаардагдах төсөв / мянган төгрөгөөр /		
			2017	2018	2019	2020		Орон нутгийн төсөл хөтөлбөр	ОНТ	ХЭДСан бусад төсөл
Нэг. Алтайн малчин төслийг боловсруулан батлуулах	1	"Алтайн-Малчин" хөтөлбөрийн төслийг боловсруулж аймгийн ИТХурлаар батлуулах					ХХҮГазар			
	2	Төслийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан ХХҮГ-ын даргаар батлуулж хэрэгжилтийг зохион байгуулах					ХХҮГазар			
Хоёр. Ахмад алдар цолтой малчдыг ажлын дадлага, туршлагыг залуу малчдад өвлүүлэх, туршлага судлуулах арга хэмжээг зохион байгуулна.	1	Монгол улсын гавъяат, хөдөлмөрийн баатар, улсын болон аймгийн сайн малчдын судалгааг сумдаар гаргаж мэдээллийн сан бүрдүүлнэ.					ХХҮГазар			
	2	Аймгийн хэмжээнд "САЙН МАЛЧДЫН ХОЛБОО"-г байгуулж үйл ажиллагааг нь идэвхижүүлнэ.					ХХҮГазар			
		Алдар цолтой ахмад малчидтай хамтран мал маллах арга ухааныг залуу хойч үед өвлүүлэх ажлын хүрээнд Монголын үндэсний радио, аймгийн радиотой хамтран "Хөрөг" нэвтрүүлэг зохион байгуулна.					ХХҮГазар	2000.0		
		Нэвтрүүлэгт оролцсон мэргэжлийн болон ахмад зөвлөхүүдийн ажлын дадлага туршлага, зөвлөмжөөр гарын					ХХҮГазар			

		авлага ном товхимол хэвлүүлэн залуу малчдад хүргэнэ.							
		Аймгийн малчдын зөвлөгөөнийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.				ХХҮГазар	1500.0		
		Хөтөлбөрт хамрагдсан малчин өрхийг туршлага судлуулах арга хэмжээнд хамруулна.				ХХҮГазар		5000.0	3100.0
Гурав.40-өөс доош насны богд шилжүүлснээр 100 хүртэл толгой малтэй малчин өрхийг малжуулна.	1	40-өөс доош насны залуу малчдын судалгааг сумдаар нарийвчлан гаргах				ХХҮГазар			
	2	Залуу малчдыг хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.				ХХҮГазар			
	3	Цөөн малтай залуу малчдыг сумдын амьжиргааг дэмжих зөвлөлийн саналыг үндэслэн малжуулах арга хэмжээнд хамруулж ажлын байрны тогтвортой байдлыг хадгална.				ХХҮГазар		50000.0	135000.0
Дөрөв. Малаас гарах түүхий эд бүтээгдэхүүн боловсруулах сургалт зохион байгуулна.	1	Малчдаас ур чадвар олгох сургалтын хэрэгцээний судалгаа авах				ХХҮГазар			3000.0
	2	Эрэлтэд нь үндэслэн эрх бүхий сургалтын байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах				ХХҮГазар			
		Нийт дүн					3500.0	55000.0	141100.0